



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 05/12

Улаанбаатар хот

2017 1 1 13 1 34

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Нэг талаас “Нью сити принт” / цаашид гүйцэтгэгч гэх / нөгөө талаас “Эрүүл мэндийн хөгжлийн төв”-ийн / цаашид захиалагч гэх / нар харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтран ажиллах гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээний зорилго нь

№	Нэр	Хэмжээ	Үзүүлэлт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Сэтгүүл /ЭМИЙН МЭДЭЭЛЭЛ, эмнэлэгийн мэргэжилтэнд зориулсан улирал тутмын товхимол/	A4	Хавтас-250гр матт цаас бүрэлттэй, 4+0 өнгө Дотор- 80 гр матт цаас, 82 нүүр 4+4 өнгө	2.000ш	2.200₮	4.400.000₮

хэвлэх ажлыг зохицуулахад оршино.

1.3 Дээрх номыг чанарын өндөр түвшинд хэвлэж, захиалагч талд хүлээлгэн өгнө. Ном хэвлэлтийн нийт зардал 4,400,000 төгрөг /Дөрвөн сая дөрвөн зуун мянган төгрөг/

1.4 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

1.5 Хэвлэлийн бүтээгдэхүүний хэвлэх ажлыг тухайн бүрт нь хавсралтаар батална.

ХОЁР. Захиалагчийн эрх үүрэг

2.1 Захиалагч тал эх загварын алдааг шалгасны эцэст хэвлэх зөвшөөрөл олгон гарын үсэг зурж баталгаажуулна.

2.2 Захиалагч тал баталсан эх загвар дээрх алдааг бүрэн хариуцна.

2.3 Захиалгат ажлыг гүйцэтгэх явцад захиалагчийн зүгээс хянах, зөвлөх үүрэг хариуцлага бүхий хүнийг ажиллууна.

2.4 Гэрээнд тусгагдсан хугацаанд төлбөрийг хийж гүйцэтгэнэ.

2.5 Хэрэв захиалагчаас үүдэлтэй шалтгаанаар бүтээгдэхүүнийг ажлын бус цагаар хүлээн авах шаардлагатай болсон бол захиалагч өөрсдийн унаагаар очиж авна.

ГУРАВ. Гүйцэтгэгчийн үүрэг

- 3.1 Гүйцэтгэгч тал Захиалагч талыг эх загвараа баталгаажуулж гарын үсэг зурсны дараа баталсан загварын дагуу чанарын өндөр түвшинд хэвлэнэ.
- 3.2 Захиалгат ажлыг тогтоосон хугацаанд бэлэн болгож, ажлын цагаар хүргэж өгнө.
- 3.3 Гэрээнд заагдсан тооноос илүү хэвлэх, захиалагчтай тохиролцоогүйгээр дахин хэвлэхийг хориглоно.
- 3.4 Захиалагчийн баталсан загвар нь алдаатай байсан өөрөөр хэлбэл захиалагчаас шалтгаалсан нь хэвлэгдсэний дараа илэрсэн тохиолдолд үүнээс үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч хариуцахгүй.
- 3.5 Гүйцэтгэлийн явцад захиалагчийн баталсан загвар дээр байхгүй шинээр нэмж алдаа гаргасан нь тогтоогдсон тохиолдолд гүйцэтгэгч хариуцна.
- 3.6 Бэлэн болох хугацааг загвар баталснаас хойш бүтээгдэхүүний онцлогийг харгалзан тогтоосон хугацаанд бэлэн болгон.
- 3.7 Гүйцэтгэгч нь захиалсан хэвлэмэл бүтээгдэхүүнийг тохиролцсон хугацаа, захиалсан өгөгдөл, тоо ширхэгийн дагуу захиалагч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 3.8 Гүйцэтгэсэн ажлыг актаар хүлээлцэх үед гүйцэтгэгчийн буруугаас үүссэн аливаа гологдол, доголдлыг 5 хоногийн дотор өөрийн зардлаар дахин хийж гүйцэтгэнэ.
- 3.9 Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсан захиалагчыг ямар нэгэн хүндрэл чирэгдэл үүсгэхгүйгээр үйлчлэх үүрэгтэй бөгөөд оргил ачааллын үед компанийн хүрээнд аль болох хурдан шуурхай зохицуулах үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ. Талуудын хариуцлага

- 4.1 Гүйцэтгэгч тал хэвлэлийн чанарын гологдол гаргасан тохиолдолд захиалагч талыг хохиролгүй болгоно.

ТАВ.Төлбөр тооцоо

- 5 Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс **4,400,000 төгрөг** /дөрвөн сая дөрвөн зуун мянган төгрөг/-ийг нэхэмжлэхийн дагуу **“Төрийн банк” 109500002389** тоот дансанд тооцоог шилжүүлсэнээр хэвлэлийг хийж гүйцэтгэнэ.

ЗУРГАА. Бусад зүйл

- 6.1 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчинтэй болох бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг нь байна.
- 6.2 Талууд энэхүү гэрээгээр тодорхойлсон үүргээ гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа учирсан хохиролыг бүрэн хариуцаж, арилгана.
- 6.3 Гэрээний явцад гарсан маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх ба тохиролцохгүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 6.4 Энэхүү гэрээг 3% үйлдэх бөгөөд тус бүр хүчин төгөлдөр болно.

Гэрээ байгуулсан

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ:

"НЬЮ СИТИ ПРИНТ" ХХК-ийн

Ерөнхий менежер:

 /П.Бат-Өлзий/

Хаяг: Улаанбаатар Баянзүрх, 6-р хороо, "Шинэ-Од" трейд байр /69-1 тоот/

Утас: 99758888, 99529212

ЗАХИАЛАГЧ ТАЛ:

"ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН

ТӨВ"-ийн ЭЭХАалбаны дарга

 /Г.Цэцэнсанаа/ - 2

Хаяг: Улаанбаатар хот-46 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15

Утас: 99072126